

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Зорилго: Батлан хамгаалах яам, харьяа байгууллага, нэгжийн бие бүрэлдэхүүнийг авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан, нөхцөлийн арилгах, ил тод байдлыг хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэхэд оршино.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлах, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг хангах			
1	1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах	Авлигын эсрэг хууль тогтоомжийг Батлан хамгаалах салбарын хэмжээнд сурталчилсан байдал	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах боломж, нөхцөлийг хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч, боломжит хэлбэрээр сурталчилж байна.</p> <p>Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг нээлттэй түргэн шуурхай, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөмж, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Батлан хамгаалах яамнаас бэлтгэсэн “Авлигалын эсрэг нэгдье” шторкийг Батлан хамгаалах яам, Соёмбо редакц, АТГ-ыг Олон нийтийн төвийн цахим хуудаснуудад байршуулан сурталчилсан бөгөөд 106 лайк, 54 шайр авсан хандалттай байна.</p>
2	1.2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байдал	<p>“Стратегийн нөөц, батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийн худалдан авалт, зарцуулалтыг нууцаас гаргах, ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж заасныг Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2024 онд зохион байгуулсан материал хэрэгслийн худалдан авалтыг олон нийтэд нээлттэй байдлаар худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулсан.</p> <p>Энхийг дэмжих ажиллагаанд шаардлагатай 2,023,064.2 мянган төгрөгийн материал хэрэгслийн худалдан авалтыг “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ-аар гүйцэтгүүлсэн.</p>

			Стратегийн нөөц, батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийн худалдан авалтыг хуулийн дагуу ил тод нээлттэй байдлаар зохион байгуулан ажиллаж байна.
3	1.3.Салбарын хэмжээнд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх	АТГ-аас зохион байгуулсан “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль”-ийн хэлэлцүүлэгт оролцох	Авлигалтай Тэмцэх газраас 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин, хэрэгцээ шаардлага” сэдэвт хэлэлцүүлэгт Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ЭБАТ дэд хурандаа Х.Мөнхзаяа, Цэргийн төв эмнэлгийн Дайчилгаа, хүний нөөцийн тасгийн дарга дэд хурандаа Д.Өлзийдаваа, Цэргийн төв эмнэлгийн хуулийн офицер ахмад Б.Тамжид, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын хуулийн офицер дэслэгч Г.Сумъяабаяр, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн хуулийн офицер ахлах дэслэгч Т.Энхтуул, Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн хуулийн офицер ахлах дэслэгч Д.Мөнх-Эрдэнэ нар оролцогчоор, “Цэргийн алба хаагчийн шүгэл үлээх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн нөхцөл, өөрчлөлт хийх боломж, авах арга хэмжээний санал” сэдвээр илтгэгчээр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хуулийн офицер дэслэгч Б.Эрдэнэбат оролцож тус бүрийн илтгэлийг сонсож, хэлэлцүүлэг өрнүүлсэн нь тус шүгэл үлээгчийн тухай хуулийн төслийг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ болсон.
4	1.4.Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Салбарын хэмжээнд “Шүгэл үлээгчийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх	Салбарын хэмжээнд “Цэргийн алба хаагчийн шүгэл үлээх эрх зүйн орчныг бүрдүүлэх” сэдвээр уулзалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулаагүй.
5	1.5.Салбарын хэмжээнд худалдан авах ажиллагаанд оролцогч, ажил гүйцэтгэл хангалтгүй, хариуцлагагүй аж ахуйн нэгжүүдийн талаар “Ажлын гүйцэтгэлийн түүх”		Гэрээний үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн талаар “Ажлын гүйцэтгэлийн түүх” үүсгэж, тендерийн үнэлгээний хорооны гишүүдийг мэдээллээр хангах зорилго бүхий 2022-2024 онд хийгдсэн алдаа, зөрчил гаргасан нийлүүлэгчдийн жагсаалтыг гаргав. Үүнд: 1. Барилгын засварын материал нийлүүлэх тендер

	<p>мэдээллийг 2020-2023 оны байдлаар санг өргөтгөж мэдээллийг баяжуулан ил тод байршуулах</p>		<p>Захиалагч байгууллага: Батлан хамгаалах яам Чанаргүй ажил гүйцэтгэсэн байгууллага: Угалз бүс бараа ХХК</p> <p>2. Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендер Захиалагч байгууллага: Цэргийн төв эмнэлэг; Чанаргүй ажил гүйцэтгэсэн байгууллагууд 1. “Монос трейд” ХХК; 2. “Мөнхийн тун” ХХК;</p> <p>Дүгнэлт: - Батлан хамгаалах яам 2023 оны хэрэгцээт цахилгааны материал хэрэгсэл худалдан авах 157,162,600 төгрөгийн тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Уг тендерт Угалз бүс бараа ХХК (регистрийн дугаар 6600956) 157,049,500.00 төгрөгийн цахилгааны материал хэрэгсэл бэлтгэн нийлүүлэхээр шалгарсан. Угалз бүс бараа ХХК нь гэрээний дагуу нийлүүлэх “Цахилгааны утас кг 3x120+1x70” загварын зэс голтой цахилгааны утсыг олон улсын зах зээл дээр зэсийн үнэ өссөнтэй холбоотойгоор үнэ нэмэгдсэн тул нийлүүлэх боломжгүй гэдгээ мэдэгдэж, гэрээнд заагдсан 64,960,000.00 төгрөгийн цахилгааны утсыг нийлүүлээгүй. - “Монос трейд” ХХК нь 2023 онд Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалтаар “Зүрх судас болон цусны даралт бууруулах эм”-ийн багцад шалгарч гэрээ байгуулсан бөгөөд Прозерин, Дигоксин эмүүдийн нийлүүлэлт хийгдэлгүй тасалдал үүсгэсэн. Мөн “Монос трейд” ХХК нь 2024 онд Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх БХЯ/2024010222 дугаартай тендерт шалгарч 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд “Нянгийн эсрэг бэлдмэл” багцад Лизомак 600мг, “Зүрх судас болон цусны даралт бууруулах эм”-ийн багцад Кардионат 100мг/мл-5мл, Атропин 1%-1мл, “Даавар дотоод шүүрэл, элэг цөс, ходоод гэдэс, нойр булчирхайн эм”-ийн багцад Панзинорм, Сандостатин 0.1мг/мл-1мл зэрэг эм тариаг тус тус нийлүүлээгүй тасалдал үүсгэж байна. Тус компаниас Цэргийн төв эмнэлэгт</p>
--	---	--	--

			<p>дээрх эмүүдийн нийлүүлэлт тодорхойгүй хугацаагаар хойшилсон мөн нийлүүлэх боломжгүй болсон талаар 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 1500 дугаар, 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1757 дугаар албан бичиг тус тус ирүүлсэн.</p> <p>- “Мөнхийн тун” ХХК нь 2024 онд Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерт шалгарч 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд “Эмнэлгийн резин ба жижиг хэрэгсэл”-ийн багцад Нэг удаагийн үзлэгийн бээлий нь савлагаа дотроо наалдсан, салгах явцад урагдаж цоордог зэргээр чанарын шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн.</p> <p>Дээрх жагсаалтыг яамны цахим сайт дээр байршуулан ил тод байдлыг хангасан бөгөөд АТГ-т хүргүүлэн ажиллаа.</p>
Хоёр. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах			
6	2.1.Сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	Авлигын эсрэг сургалт зохион байгуулсан байдал	<p>Батлан хамгаалах яам Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан мэргэжилтэн дэд хурандаа Х.Мөнхзаяа, Цэргийн төв эмнэлгийн Хуулийн офицер ахмад Б.Тамжид, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Захиргааны удирдлагын хэлтсийн хуулийн зөвлөх, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн М.Пүрэвсүрэн, Соёмбо редакцын Захиргааны албаны дарга, ерөнхий нягтлан бодогч М.Заяа, Монгол цэргийн музейн Хүний нөөцийн ажилтан, архив, бичиг хэргийн эрхлэгч, номын санч Б.Оюунцэцэг, Батлан хамгаалахын төв архивын Ерөнхий нягтлан бодогч Ж.Алтантуул, "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын Архив, бичиг хэргийн ажилтан М.Гантөмөр нар АТГ-аас зохион байгуулсан сургагч багшийн дамжаанд хамрагдаж “Сургагч багшийн сертификат” авч төгссөн бөгөөд тус тусын байгууллагын алба хаагчдад “Авлигалын эсрэг хууль” тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсаар байна.</p>
7	2.2.Батлан хамгаалах салбарын хэмжээнд гадаадын зээл тусламж болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд хариуцсан	Төсөл хөтөлбөрийн нэгжтэй уулзалт зохион байгуулах	<p>Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа тендер шалгаруулалт, худалдан авах үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулан явууллаа. Тус сургалтад Батлан хамгаалах</p>

	<p>нэгжтэй уулзалт зохион байгуулах</p>		<p>яам, харьяа байгууллага, ЗХЖШ-ын “Олон улсын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн үйл ажиллагаа хариуцсан нэгж болон нийт 43 албан хаагчид оролцсон бөгөөд “БХЯ, харьяа байгууллагад хэрэгжиж байгаа Олон улсын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн тухай товч мэдээлэл, 2024 оны худалдан авах төлөвлөгөө, хэрэгжилтийн явц хяналт (2023 оны аудитын зөвлөмж түүний хэрэгжилт)”-ын талаар яамны БХЗГ-ын Материал хэрэгслийн хангалт, худалдан авах ажиллагааны бодлогын хэрэгжилт хариуцсан шинжээч хошууч Д.Мөнхбат, “ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, удирдах газарт хэрэгжиж байгаа Олон улсын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн талаарх товч мэдээлэл, 2024 оны худалдан авах төлөвлөгөө, хэрэгжилтийн явц хяналт (2023 оны аудитын зөвлөмж түүний хэрэгжилт)”-ын талаар ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Материал хангалтын хэлтсийн дарга хурандаа Ө.Тамир нар товч мэдээлэл хийж, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон улсын зээл, тусламж, төслийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой эрсдэлээс хамгаалах, анхаарах асуудал”-ын талаар Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан ахлах комиссар Б.Тэрбиш, ажилтан комиссар Ж.Мөнхжаргал нар мэдээлэл хийж, асуулт, хариулт өрнүүлсэн сургалтыг зохион байгуулсан.</p>
8	<p>2.3.Иргэд, Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах бүх төрлийн гэрээнд хяналт тавих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тусгах</p>	<p>Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах.</p>	<p>Батлан хамгаалах яамнаас 2024 онд Улсын төсөв, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн санхүүжилт, “Эрдэнэс Таван Толгой” ХК-ын санхүүжилтээр нийт 44 арга хэмжээний 174 багц тендерт шалгарсан байгууллагуудтай 53,7 тэрбум төгрөгний 216 гэрээ байгуулан ажилласан бөгөөд байгуулсан гэрээнүүдэд “Талууд авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс ангид байж, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гарсан, гарах нөхцөл бүрдсэн тохиолдолд нэн даруй эрх бүхий байгууллага, этгээдэд мэдэгдэнэ.” гэсэн заалтыг бүх байгуулсан гэрээний заалт болгон тусгаж, хяналт тавьж ажиллаа.</p>

9	2.4.Салбарын авлигын эсрэг сурталчилгааны зохион байгуулах хэмжээнд сургалт, ажлыг	Салбарын хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдлэгийн түвшин	<p>Батлан хамгаалах яам, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Батлан хамгаалах яамны “Бөртэ” Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдах бүрэлдэхүүнтэй уулзаж, зөвлөмж өгч, сургалт зохион байгууллаа.</p> <p>Тус уулзалт, сургалтын үйл ажиллагаанд тус үйлдвэрийн газрын захирал дэд хурандаа Б.Ганжигүүр, АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн тухайн байгууллагыг хариуцсан ажилтан, комиссар Ж.Мөнхжаргал, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, яамны ЭБАТ дэд хурандаа Х.Мөнхзаяа, тус үйлдвэрийн газрын Захиргаа удирдлагын тасгийн дарга ахлах дэслэгч А.Сүх, Үйлдвэрлэлийн албаны дарга ахмад Н.Мөнхзул, Санхүүгийн албаны дарга дэслэгч М.Далайжаргал, Нууцын дарга, архивын эрхлэгч ахалах ахлагч Б.Билгүүн, эдийн засагч А.Сувд, чанар нормчлолын инженер Б.Занданхүү, ахлах загвар зохион бүтээгч Г.Буянзаяа нарын хүрээнд зохион байгуулж, тендер шалгаруулалт, худалдан авах үйл ажиллагаатэй холбоотой үйл ажиллагаанд тандалт хийв.</p> <p>Уулзалтаар тус байгууллагын Захиргаа удирдлагын тасгийн дарга ахлах дэслэгч А.Сүх чиглэлийн мэдээллийг хүргэж, АТГ-ын ажилтан нь худалдан авах төлөвлөгөө, түүнийг дагасан зарим үйл ажиллагаа болон бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ болон архивын баримт бичигтэй танилцав.</p> <p>АТГ-ын ажилтан нь холбогдох албан хаагч нарт худалдан авалтын үйл ажиллагааны төлөвлөлт, ил тод байдал, зарим үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийг багасгах, урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах талаар холбогдох арга хэмжээг авах тухай асуудлаар мэдээлэл хүргэж, гэрээ байгуулах, дүгнэх, хяналт тавихтай холбоотой асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.</p> <p>Мөн Батлан хамгаалах яам, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Батлан хамгаалах яамны “Бөртэ” Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Барилга захиалагчийн алба Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Захиргааны удирдлагын бүрэлдэхүүн болон ажилтан албан хаагчдад</p>
---	--	--	--

			<p>“Батлан хамгаалах салбарын шударга байдал, авлигаас урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр танилцуулга, сургалт явуулсан бол “Засгийн газрын өргөдөл, гомдол хүлээн авах 11-11 төв”, “Авлигыг мэдээлэх утас 110” дугаарыг хэрхэн ашиглах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан явууллаа.</p> <p>Тус сургалтын үйл ажиллагаанд Батлан хамгаалах яамны “Бөртэ” Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Барилга захиалагчийн алба Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал дэд хурандаа Б.Ганжигүүр, ахмад Э.Мөнхнаран, АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргал, БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, яамны ЭБАТ дэд хурандаа Х.Мөнхзаяа болон байгууллагуудын нийт 160 гаруй ажилтан албан хаагч оролцож, мэдээлэл сонслоо.</p> <p>Мөн энэ үеэр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргал нь тус байгууллагуудын удирдлагад өөрийн байгууллагын цахим хаягийг хэрхэн хөтлөх, ил тод байдлыг хэрхэн хангаж ажиллах болон шилэн дансны мэдээллийг хэрхэн хөтлөх талаар зөвлөмж өгч, цахим хаягтай нь танилцаж ажиллаа.</p>
10	<p>2.5.Салбарын хэмжээнд алба хааж байгаа нэр хүндтэй, олонд хүлээн зөвшөөрөгдсөн офицер, ахлагч, ажилтан, спортын салбарт шударга хөдөлмөрөөр амжилт гаргаж буй тамирчдыг болон төлөөллийг оролцуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд татан оролцуулах, видео бичлэг, шторкийг дотоод нөөц бололцоонд тулгуурлан бүтээх</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр дүн</p>	<p>Франц Улсад зохион байгуулагдсан “Парис-2024” зуны паралимпын наадмын Паратаеквондогийн төрлөөс алт, мөнгөн медаль хүртсэн Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны Үндэсний спортын албаны өвлийн оюуны спортын тамирчин Уламбаярын Сүрэнжав, Их спортын албаны тулааны спортын бүлгийн тамирчин Ганбатын Болор-Эрдэнэ нарыг оролцуулан “Цэргийн алба хаагчид бид ямагт Авлигаас ангид байж, Төрийн албаны ёс зүй, шударга ёсыг эрхэмлэн хуулийг дээдэлж, эх орон, төр, ард түмэндээ өргөсөн андгай, тангаргаа үнэнчээр биелүүлдэг билээ”, “Авлигагүй нийгмийн төлөө Иргэн Та Батлан хамгаалах салбарын офицер, ахлагч, ажилтан, албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг БХЯ-ны 1800-1144, Авлигатай тэмцэх газрын 110 тусгай дугаарт хандаж эсвэл “Товш” аппликейшн ашиглаж</p>

			<p>зөвлөгөө, мэдээлэл аваарай.”, “Авлигын эсрэг хамтдаа, Үгүй гэж хэлээд өөрчилъе.” гэсэн сэдвээр шторк бэлтгэн сурталчилгааны ажлыг Батлан хамгаалах яам, Соёмбо редакцын цахим хуудсаар сурталчлах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд АТГ-ын Олон нийтийн төвийн цахим хуудсанд АТГ-ын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан комиссар Ж.Мөнхжаргалтай хамтран байршуулан ажиллаж байна.</p> <p>Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Хүний эрхий Үндэсний комиссын дарга Д.Сүнжидийг хүлээн авч уулзсан уулзалтын үеэр хамтын ажиллагаа, харилцаагаа улам өргөжүүлэх ажлын санал солилцон Батлан хамгаалах салбарын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулах талаар харилцан тохиролцсон. Уг ажлын хүрээнд Батлан хамгаалахын сайдаар “Хүний эрхэд суурилсан хандлага, авлигаас урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалтын удирдамжийг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр батлуулсан.</p> <p>Сургалтын удирдамжийг Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн 2024 оны 02/3480 дугаар албан бичгээр Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалууд, Барилга, инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын захирагч, яамны харьяа байгууллагын дарга, захирал, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нар т хүргүүлж, Хүний эрхийн Үндэсний комисс, Авлигатай тэмцэх газартай хамтран 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.</p> <p>Тус сургалтад Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал Ж.Өсөхбаяр, ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Б.Баатар болон БХЯ, ЗХЖШ-ын газар хэлтсийн дарга нар, БХЯ-ны харьяа байгууллагын захирал, дарга нар, нийслэл дүүргийн ЗДТГ-ын цэргийн штабын дарга, ахлах офицерууд танхимаар 100 цэргийн алба хаагч, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын захирагч нар, аймгийн ЗДТГ-ын цэргийн штабын дарга, ахлах офицерууд цахимаар 117 цэргийн алба хаагч нийт 217 цэргийн алба хаагч сургалтад хамрагдсан.</p>
--	--	--	--

			<p>Тус сургалтад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Б.Тэрбиш “Батлан хамгаалах салбарын удирдлагын манлайлал, авлигаас урьдчилан сэргийлэх тухай” сэдвүүдээр нийт 4 цагийн лекц уншсан бөгөөд сургалтыг Батлан хамгаалах яамны “Дуулга” студи, “Соёмбо” сонин, МҮОНРТ, “ТВ9”, “Малчин”, “Ийгл Тв”, “TV-5” телевизүүд, БХЯ, ЗХЖШ, ХЭҮК, АТГ-ын цахим хуудсуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлан ажилласан.</p>
<p>Гурав. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах</p>			
11	<p>3.1.ЗГХГ-ын ОНХТ-ийн 1111, Батлан хамгаалах яамны тусгай дугаар “1800-1144”, “11458929” дугаарт иргэд, төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх</p>	<p>Авлигын эсрэг гомдол, мэдээллийг түргэн шуурхай шийдвэрлэсэн байдал</p>	<p>Батлан хамгаалах яаманд 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр-128, 1800-1144 тусгай дугаараар-72, 11458929 дугаараар-84, нийт-284 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирсэн.</p> <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу бүртгэл хөтлөлтийг хийж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар дээрх сувгуудаар алба хаагч, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна. (Хариу өгсөн-284 өргөдөл, гомдол байна.)</p> <p>Тухайн сувгуудаар алба хаагч, иргэдээс ирсэн өргөдөл, гомдол дунд авлигал, албан тушаалын хэрэгт хамааралтай өргөдөл, гомдол ирүүлээгүй болно.</p>
12	<p>3.2.“Товш” аппликэйшнийг олон нийтэд сурталчлан таниулах, салбарын хэмжээнд санал, өгөх ажлыг зохион байгуулах</p>	<p>Товш” аппликэйшнийг олон нийтэд сурталчлан таниулсан байдал</p>	<p>АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргалтай хамтран яамны харьяа “Бөртэ” ТӨААТҮГ-ын 160 гаруй ажилтан албан хаагч, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 10 ажилтан албан хаагчдад “Товш” аппликэйшнийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус сургалтад хамрагдсан алба хаагчдын гар утсанд “Товш” аппликэйшнийг татаж суулгах, хэрхэн ашиглах зааврыг өгч ажиллаа.</p>

13	3.3.Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй сайжруулах байдлыг	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасныг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах.	<p>Батлан хамгаалах яамнаас харьяа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод байдлыг сайжруулах үүднээс хяналт, шалгалтын ажиллагааг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар явуулж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газрын 2024 оны 03/14362 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Хуулийн хэрэгжилтийг хангах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын Хяналт шалгалтын хэлтсээс Батлан хамгаалахын сайдын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хэсэгчилсэн хяналт шалгалт зохион байгуулсан.</p> <p>Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудад Батлан хамгаалахын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1а/4090 дүгээр, яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1в/4091 дүгээр “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” албан бичгийг хүргүүлж, үүрэг чиглэл өгч ажилласан.</p> <p>Батлан хамгаалахын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр баталсан удирдамжаар Батлан хамгаалах салбарын удирдах бүрэлдэхүүнтэй “Хүний эрхэд суурилсан хандлага, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ” сэдэвт сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1в/4105 дугаар албан бичгээр авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.</p>
----	--	---	---

Дөрөв. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх		
14	4.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах, үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох судалгаа авах, дүгнэлт гаргах	Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ, судалгааны үр дүн

Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.1-д “Төрийн байгууллага, албан тушаалтан ... авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ... ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.”, 5.1.1.2-т “төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх.” гэж заасан зохицуулалтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд яамны алба хаагчдаас 2024 оны 05 дугаар сард “Авлигын эрсдэлийг үнэлэх судалгаа”-г авч, Авлигын эрсдэлтэй, авлигад өртөх магадлалтай албан тушаалын жагсаалтыг гаргаж нэгтгэсэн.

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТАН
ДЭД ХУРАНДАА Х.МӨНХЗАЯА

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ОДХҮҮ